



МОНГОЛ УЛСЫН  
ГАДААД ХЭРГИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2015 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/109

Улаанбаатар хот

“Заавар батлах тухай”

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, “Төрийн ёслолын журам батлах тухай” Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 297 дугаар зарлигийн хавсралтын 59.4-т заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. “НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн байнгын гишүүн улс болон Монгол Улстай стратегийн түншлэлийн харилцаатай улсын Гадаад хэргийн сайдыг угтах, үдэх заавар”-ыг хавсралтаар батласугай.

2. Энэ тушаалын 1-д заасан зааврын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ёслолын газрын захирал /Д.Тэгшжаргал/, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Д.Ганхуяг/-д тус тус үүрэг болгосугай.



Л.ПҮРЭВСҮРЭН

Гадаад хэргийн сайдын 2015 оны  
А/109 дугаар тушаалын хэвсрэлт



**НҮБ-ЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН БАЙНГЫН ГИШҮҮН УЛС  
БОЛОН МОНГОЛ УЛСТАЙ СТРАТЕГИЙН ТҮНШЛЭЛИЙН ХАРИЛЦААТАЙ УЛСЫН  
ГАДААД ХЭРГИЙН САЙДЫГ УГТАХ, ҮДЭХ ЗААВАР**

1. Төрийн ёслолын журмын 59.4-т "Гадаад хэргийн яам энэ журамд заасан дипломат ёслолын үйл ажиллагааг тухайн цаг үеийн онцлог, гадаад улс, олон улсын байгууллагын ёслолын журам, олон улсын харилцааны тухайн үеийн дэгт нийцүүлж, уян хатан хэрэгжүүлж болно" гэж заасныг үндэслэн, олон улсын жишгийг харгалзан НҮБ-ын Аюулгүй байдлын зөвлөлийн байнгын гишүүн улс болон Монгол Улстай стратегийн түншлэлийн харилцаатай улсын Гадаад хэргийн сайдыг угтах, үдэхэд энэ зааврын дагаж мөрдөнө.

2.Зочныг Монгол Улсад тусгай үүргийн нислэгээр ирэхэд Төрийн ёслолын журамд зааснаар гадна дараах байдлаар угтах, үдэх ёслолыг зохион байгуулна:

2.1.Улаан хивсний хоёр талд Хүндэт харуулын тус бүр 6 цэргийг байрлуулсан байна.

2.2.ГХЯ-ны Ёслолын газрын захирал онгоцонд орж зочныг урих бөгөөд тухайн улсын Элчин сайд байлцаж болно.

2.3.ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, чиглэлийн газрын захирал, ГХЯ-ны Ёслолын газрын захирал угтах бөгөөд монголын талын төлөөлөгчдийг ГХЯ-ны Ёслолын газрын захирал танилцуулна.

2.4.Гадаад хэргийн сайд, чиглэлийн газрын захирал, ГХЯ-ны Ёслолын газрын захирал онгоцны буудлаас үднэ.

3.Зочныг Монгол Улсад хуваарьт нислэгээр ирэж, буцахад Төрийн ёслолын журамд зааснаар гадна дараах байдлаар угтах, үдэх ёслолыг зохион байгуулна:

3.1.Зочныг ГХЯ-нд ирэхэд автомашины хаалганаас төв хаалга хүртэлх зам дагуу улаан хивс дэвсэх ба хоёр талд Хүндэт харуулын тус бүр 6 цэргийг байрлуулсан байна.

3.2.ГХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, чиглэлийн газрын захирал, ГХЯ-ны Ёслолын газрын захирал онгоцны буудлаас угтаж, үднэ.